

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

### БУЯНТ СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын код: ХОА-2021/153/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsuren.A@audit.gov.mn Тунгалаг бүртгэл аудит ХХК Аудитор: Ч.Мөнхцооз Цахим хаяг: Auit.munhoo@yahoo.com Утас: 99028555</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	
3. Аудитын тайлан.....	3
3.1. Ерөнхий зүйл.....	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт .....	11
3.4. Материаллаг байдал .....	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	13
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	14
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
3.9. Аудитын илрүүлэлт.....	14
Залруулсан алдаа.....	14
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	14
Аудитын зөвлөмж.....	
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	15
4. Менежментийн захидал.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	16

## 1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
84000 Цэнхэрлэн баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 978-70433061, Факс: 978-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

2021.02.25 № 2/105  
тшнай -ны № -т

БУЯНТ СУМЫН  
СОЁЛЫН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ  
Б.МАГСАРЖАВ ТАНАА

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Буянт сумын соёлын төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Буянт сумын соёлын төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй. Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, ард иргэдэд соёлын үйлчилгээг хүртээмжтэй хүргэх, үндэсний язгуур өв соёлоо түгээн дэлгэрүүлэх ажлын хэрэгжилт зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

001020300

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЯДБААТАР

### 3.Аудитын тайлан

#### 2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>414,689.54</b>	<b>2,870,274.45</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	264,689.54	930,274.45
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	264,689.54	930,274.45
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	150,000.00	1,830,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	150,000.00	1,830,000.00
35420	Аж ахуйн материал	-	1,680,000.00
35470	Бусад хангамжийн материал	150,000.00	150,000.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	-	110,000.00
36100	Барааны нөөц	-	110,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>70,664,981.30</b>	<b>1,271,558,324.30</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	70,664,981.30	1,271,558,324.30
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	69,865,106.30	1,270,872,699.26
39201	Барилга, байгууламж, орон сууц	45,515,399.30	1,217,861,377.30
39202	Хуримтлагдсан элэгдэл	(3,501,185.00)	(7,002,369.56)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	17,255,300.00	20,405,300.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(11,669,800.00)	(13,130,299.96)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,459,378.00	48,627,378.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(12,098,678.00)	(13,793,378.52)
39217	Ном	15,904,692.00	17,904,692.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	799,875.00	685,625.04
39301	Програм хангамж	457,000.00	457,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(57,125.00)	(171,374.96)
39303	Бусад биет бус хөрөнгө	400,000.00	400,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>71,079,670.84</b>	<b>1,274,428,598.75</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>27,996.00</b>	<b>54,688.40</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	27,996.00	54,688.40
<b>413</b>	<b>Өглөг</b>	27,996.00	54,688.40
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	27,996.00	23,381.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	31,307.40
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>71,051,674.84</b>	<b>1,274,373,910.35</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	71,051,674.84	1,274,373,910.35
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	71,660,856.00	71,660,856.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(42,246,534.29)	1,161,075,701.22
51210	Өмнөх үеийн үр дүн	(42,246,534.29)	(41,998,571.29)
51220	Тайлант үеийн үр дүн	-	1,203,074,272.51
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	41,637,353.13	41,637,353.13
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>71,079,670.84</b>	<b>1,274,428,598.75</b>

#### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>70,174,902.00</b>	<b>1,281,407,721.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>8,916,302.00</b>	<b>1,211,750,221.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	6,416,302.00	1,211,750,221.00

120003	Торгуулийн орлого	174,302.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,242,000.00	1,206,477,841.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	100,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,242,000.00	1,206,377,841.00
120009	Бусад орлого		5,272,380.00
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	2,500,000.00	-
123002	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	2,500,000.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>61,258,600.00</b>	<b>69,657,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	61,258,600.00	69,657,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	61,258,600.00	69,657,500.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>67,468,013.46</b>	<b>78,333,448.49</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>67,468,013.46</b>	<b>78,333,448.49</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	66,772,476.72	75,670,378.68
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	45,462,324.00	53,385,751.00
210101	Үндсэн цалин	42,341,846.00	44,023,049.00
210102	Нэмэгдэл	3,120,478.00	9,362,702.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	5,682,795.92	6,756,505.28
210201	Тэтгэврийн даатгал	3,864,302.96	4,576,408.79
210202	Тэтгэмжийн даатгал	454,623.24	538,401.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	363,698.59	430,720.83
210204	Ажилгүйдлийн даатгал	90,924.65	106,383.57
210205	Эрүүл мэндийн даатгал	909,246.48	1,076,802.06
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	6,425,496.80	4,595,107.40
210301	Гэрэл, цахилгаан	375,496.80	535,107.40
210302	Түлш, халаалт	6,000,000.00	4,010,000.00
210303	Цэвэр, бохир ус	50,000.00	50,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	727,200.00	596,000.00
210401	Бичиг хэрэг	136,600.00	60,000.00
210402	Тээвэр, шатахуун	195,900.00	200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	45,000.00	54,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	349,700.00	282,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	515,800.00	48,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	515,800.00	48,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	339,000.00	710,000.00

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	85,000.00	100,000.00
210604	Урсгал засвар	254,000.00	610,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,308,800.00</b>	<b>624,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,218,800.00	487,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	90,000.00	137,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>5,311,060.00</b>	<b>8,955,015.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	100,000.00	2,184,380.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	5,211,060.00	6,770,635.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>695,536.74</b>	<b>2,663,069.81</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>1,050,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал		910,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	140,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>1,613,069.81</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,613,069.81
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>695,536.74</b>	<b>-</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	695,536.74	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>2,706,888.54</u></b>	<b><u>1,203,074,272.51</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>2,706,888.54</u></b>	<b><u>1,203,074,272.51</u></b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>62,258,600.00</u></b>	<b><u>75,029,880.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,000,000.00</b>	<b>5,372,380.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,000,000.00	5,372,380.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	1,000,000.00	100,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	100,000.00
120009	Бусад орлого		5,272,380.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>61,258,600.00</b>	<b>69,657,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	61,258,600.00	69,657,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	61,258,600.00	69,657,500.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>62,258,600.00</u></b>	<b><u>75,029,880.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>62,258,600.00</b>	<b>75,029,880.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>61,563,063.26</b>	<b>72,206,810.19</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	45,649,119.46	53,125,853.58
210101	Үндсэн цалин	37,653,723.39	46,591,005.34
210102	Нэмэгдэл	3,477,571.00	6,534,848.24

210104	Урамшуулал	6,921.00	-
210105	Гэрээт ажлын хөлс	4,510,904.07	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>5,655,447.00</b>	<b>7,026,776.61</b>
210201	Тэтгэврийн даатгал	3,851,497.00	4,898,476.61
210202	Тэтгэмжийн даатгал	438,645.00	532,100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	377,312.00	425,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	83,518.00	106,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	904,475.00	1,064,200.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>6,425,496.80</b>	<b>6,903,800.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	375,496.80	503,800.00
210302	Түлш, халаалт	6,000,000.00	6,350,000.00
210303	Цэвэр, бохир ус	50,000.00	50,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>656,000.00</b>	<b>656,000.00</b>
210401	Бичиг хэрэг	60,000.00	60,000.00
210402	Тээвэр, шатахуун	200,000.00	200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	54,000.00	54,000.00
210404	Ном, хэвлэл	60,000.00	60,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	282,000.00	282,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>48,000.00</b>	<b>48,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	48,000.00	48,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>354,000.00</b>	<b>1,528,000.00</b>
210602	Тавилга		818,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	100,000.00	100,000.00
210604	Урсгал засвар	254,000.00	610,000.00
<b>2107</b>	<b>Томилот, зочны зардал</b>	<b>28,000.00</b>	<b>-</b>
210702	Дотоод албан томилот	28,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,637,000.00</b>	<b>2,808,380.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,500,000.00	987,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	137,000.00	137,000.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/		1,684,380.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>110,000.00</b>	<b>110,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	110,000.00	110,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>695,536.74</b>	<b>2,823,069.81</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>1,210,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,210,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>1,613,069.81</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,613,069.81
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>695,536.74</b>	<b>-</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	695,536.74	-

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-

## 2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	71,660,856.00	41,637,353.13	(45,062,273.60)		68,235,935.53
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	108,850.77		108,850.77
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	71,660,856.00	41,637,353.13	(44,953,422.83)	-	68,344,786.30
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	2,706,888.54		2,706,888.54
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	71,660,856.00	41,637,353.13	(42,246,534.29)	-	71,051,674.84
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	71,660,856.00	41,637,353.13	(42,246,534.29)	-	71,051,674.84
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	247,963.00		247,963.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	71,660,856.00	41,637,353.13	(41,998,571.29)	-	71,299,637.84
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	1,203,074,272.51		1,203,074,272.51
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	71,660,856.00	41,637,353.13	1,161,075,701.22	-	1,274,373,910.35

## 2.4 Аудит хийсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	71058500.00	69044430.19
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	71058500.00	69044430.19
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	70758500.00	68744430.19
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	53210900.00	53125853.58
210101	Үндсэн цалин	46142700.00	46591005.34
210102	Нэмэгдэл	7068200.00	6534848.24
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	7183300.00	7026776.61
210201	Тэтгэврийн даатгал	5055000.00	4898476.61
210202	Тэтгэмжийн даатгал	532100.00	532100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	425600.00	425600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	106400.00	106400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1064200.00	1064200.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	6553800.00	6553800.00
210301	Гэрэл, цахилгаан	503800.00	503800.00
210302	Түлш, халаалт	6000000.00	6000000.00
210303	Цэвэр, бохир ус	50000.00	50000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	656000.00	656000.00
210401	Бичиг хэрэг	60000.00	60000.00
210402	Тээвэр, шатахуун	200000.00	200000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	54,000.00	54,000.00
210404	Ном, хэвлэл	60,000.00	60,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	282,000.00	282,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	48,000.00	48,000.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	48,000.00	48,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>354,000.00</b>	<b>100,000.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	100,000.00	100,000.00
210604	Урсгал засвар	254,000.00	-
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>147,000.00</b>	<b>-</b>
210702	Дотоод албан томилолт	147,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,495,500.00</b>	<b>1,124,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,358,500.00	987,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	137,000.00	137,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>110,000.00</b>	<b>110,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	110,000.00	110,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>300,000.00</b>	<b>300,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>300,000.00</b>	<b>300,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	300,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>71,758,500.00</b>	<b>69,044,430.19</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>70,758,500.00</b>	<b>68,044,430.19</b>
132001	Орон нутгийн төсвөөс	70,758,500.00	68,044,430.19
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>1,000,000.00</b>	<b>1,000,000.00</b>
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	1,000,000.00

## 2:5 Нэмэлт санхүүжилтийн тайлан гараагүй

### 3.1. Ерөнхий зүйл

Буянт сумын Соёлын төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг төсвийн шууд захирагч Б.Магсаржав танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд эд хариуцагчийн тайлан, тооллого тооцоог баталгаажуулах, баримтын бүрдлийг хангаж ажиллах, орлогыг үнэн зөв бүртгэх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 2 дугаар сарын 10 -наас 2021 оны 2 дугаар сарын 15-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагатай гэрээ байгуулж Тунгалаг бүртгэл аудит ХХК-ны аудитор Ч. Мөнхцооз хариуцаж хэрэгжүүлэв.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Буянт сумын Соёлын төв нь “Олон угсаатны өвөрмөц өв соёлыг сурталчлан өвлүүлэн түгээх, хайрлан хамгаалах, иргэд малчид үйлчлүүлэгчдийн оюуны эрэлт хэрэгцээг бүрэн хангасан шинэлэг урлаг соёлын үзвэр үйлчилгээ, номын сан, шавь сургалт, музей, биет болон биет бус өвийг хөгжүүлж суралцагч үйлчлүүлэгчдийн тоог нэмэгдүүлэх” гэсэн зорилго дэвшүүлжээ.

Төр засгийн болоод аймаг орон нутгийн соёл урлагын бодлого хөтөлбөрүүдийг бүрэн хэрэгжүүлж соёлын төвийн ойрын ба хэтийн төлөвлөгөө боловсруулж соёлын өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж алсын хараа ба тэргүүлэх чиглэл, цаашид хөгжих боломжийг тодорхойлон ажилчдын мэдлэг ур чадвар, манлайлал, ёс зүй харилцаа, хандлага, хариуцлагыг нэмэгдүүлэн үйлчилгээний орчинг сайжруулан ажиллах зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай”

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Тус байгууллага нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагад 2020 онд аймгийн санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хяналт, шалгалт хийгдээгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлого сонгож, эрсдэлийн түвшинг “ дунд ” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг тайлангийн нийт зарлага 74751.3 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 747.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо. Гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Буянт сумын соёлын төвийн нь 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1201062.7 мянган төгрөгөөр буюу 17 дахин өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнг, бараа материал данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	өөрчлөлт
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	414.69	2,870.27	2,455.58

АВЛАГА	264.69	930.27	665.58
БАРАА МАТЕРИАЛ	150.00	1,830.00	1,680.00
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	70,664.98	1,269,272.19	1,198,607.21
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>71,079.67</u></b>	<b><u>1,272,142.46</u></b>	1,201,062.79
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>28.00</u></b>	<b><u>54.69</u></b>	26.69
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>71,051.67</u></b>	<b><u>1,272,087.77</u></b>	1,201,036.10
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>71,079.67</u></b>	<b><u>1,272,142.46</u></b>	1,201,062.79

Авлага данс өмнөх оноос 665,8 мянган төгрөгөөр өссөн нь 6 тн нүүрсний үнийг авлагаар бүртгэн хууль хяналтын байгууллагад шилжүүлсэнтэй холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл материаллаг дүнгээр өсөхөд аж ахуйн материалын үлдэгдэл өссөн нь нөлөөлжээ.

Буянт сумын Соёлын төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1200952,8 мянган төгрөгөөр буюу нэмэгдсэн байна. Энэ нь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 12 дугаар сарын 30-ны 291 тоот тогтоолоор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тус суманд шинээр баригдсан 240 хүний суудалтай Соёлын төвийн 1172345,9 мянган төгрөгийн өртөг бүхий барилгыг хүлээн авч данс бүртгэлд тусгасан, Оргил жи трейд ХХК-аас бэлтгэн нийлүүлсэн 1,0 сая төгрөгийн үнэ бүхий камер, хяналтын ком дэлгэц, Аймгийн төв номын сангаас хандивласан Samsung SCH маркийн 1 ширхэг принтер, УИХ-ын гишүүн Ц.Цогзолмаагаас хандивласан 1900,0 мянган төгрөгийн үнэ бүхий “Студи мастер” маркийн зөөврийн яригч, ОНХС-гийн хөрөнгөөр бэлтгэн нийлүүлсэн 12,0 сая төгрөгийн үнэ бүхий тайзны хөшиг, ойн хандиваар бэлтгэсэн 450,0 мянган төгрөгийн цонхны хөшиг, номын тавиур, яруу найрагч Л.Дагвадоржийн 15,0 сая төгрөгийн үнэ бүхий хөшөө, 2,0 сая төгрөгийн үнэ бүхий ганжуур данжуур судар зэргийг данс бүртгэлд тусган тайлагнасангаар холбоотойгоос гадна 6770,6 мянган төгрөгийн тайлангийн хугацааны элэгдлийн зардал нөлөөлсөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт / төгрөг/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	264,690	930,274	665,585
Бараа материал	150,000	1,830,000	1,680,000
Үндсэн хөрөнгө	70,664,981	1,269,272,187	1,198,607,206
<b>Нийт хөрөнгө</b>	<b>71,079,671</b>	<b>1,272,032,462</b>	1,200,952,791
Өр төлбөр	27996	54688.4	26,692
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	71,051,675	1,271,977,773	1,200,926,099
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>71,079,671</b>	<b>1,272,032,462</b>	<b>1,200,952,791</b>

Тус байгууллагын 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1205860,4 мянган төгрөгөөр хувиар өссөн байна. Төсвийн санхүүжилт данс 8398,9 мянган төгрөгөөр өссөн нь Засгийн газрын 2019 оны 472 тоот тогтоолоор цалин нэмэгдэх шинэчлэл хийгдсэнтэй холбоотой байна

Үнэ төлбөргүй хөрөнгийн орлого улс орон нутгийн төсөв, тусгай сангийн хөрөнгөөр бэлтгэн ашиглалтад хүлээн авсан хөрөнгийн дүнгээр өссөн байна.

Үзүүлэлт	өмнөх оны	тайлант оны	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Төсвөөс олгосон санхүүжилт	61,258,600	69,657,500	8,398,900
Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө	5,242,000	1,205,377,841	1,200,135,841
өөрийн орлого	1,000,000	1,000,000	-
бусад санхүүжилт	2,674,302	-	(2,674,302)
<b>Үйл ажиллагааны орлогын дүн</b>	<b>70,174,902</b>	<b>1,276,035,341</b>	<b>1,205,860,439</b>

Тайлант жилд орон нутгийн санхүүгийн дэмжлэгээр 71058,5 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг авахаас, гүйцэтгэлээр 69657,5 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч үүнээсээ 1613,0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Өөрийн орлогын 1000.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлэх төлөвлөгөөтэйгөөс, гүйцэтгэлээр 1000,0 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ. Гэхдээ энэ өөрийн орлого төлбөртэй үйлчилгээний орлогоос биш шинэ байртай болсны нээлтээр иргэд аж ахуйн нэгжийн хандив,болон туслах аж ахуйн орлогоос бүрдсэн байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй. Тайлант жилд нэмэлт дансаар ямар нэгэн гүйлгээ хийгдээгүй байна.

#### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, зарлагыг 71950,5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 892,0 мянган төгрөгөөр бууруулж 71058,5 мянган төгрөгөөр баталсан байна.

#### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 71058.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 69657.5 мянган төгрөгийг олгожээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 69657,5 мянган төгрөгийн санхүүжилт авч, өөрийн орлогоор 1000,0 мянган төгрөг, нийт 70657,5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 69044,0 мянган төгрөгийг зарцуулж 1613,0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Үзүүлэлт	өмнөх оны	тайлант оны	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Цалин хөлс нэмэгдэл урамшуулал НДШ	51,145,120	60,114,467	8,969,347

Байр ашиглалттай холбоотой зардал	6,425,497	4,245,107	(2,180,389)
Хангамж бараа материалын зардал	727,200	596,000	(131,200)
нормативт зардал	515,800	48,000	(467,800)
Бусад бараа үйлчилгээний зардал	8,654,396	8,134,635	(519,761)
бусад урсгал шилжүүлэг		1,613,070	1,613,070
<b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>	<b>67,468,013</b>	<b>74,751,280</b>	<b>7,283,267</b>

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 7283,2 мянган төгрөг буюу 10,7 хувиар өссөн нь цалин шимтгэлийн зардал 8969,3 мянган төгрөгөөр өсөж, бараа үйлчилгээний бусад зардлууд 1686,0 мянган төгрөгөөр буурсан нь цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалж үйл ажиллагаа хязгаарлагдсантай холбоотой байна.

### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд ямар нэгэн нэмэлт санхүүжилт аваагүй байна.

### **3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хуульд заасан мэдээллийг цаг тухайд нь мэдээлсэн байна.

### **3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 695,0 мянган төгрөгийн дансны үлдэгдлийг буцаан төвлөрүүлсэн нь төсвийн төлөвлөлт, зарцуулалт хяналт хангалтгүйгээс батлагдсан төсөв зарцуулагдаагүй үлдсэнд дүгнэлт хийж ажиллахыг зөвлөсөн байна. Уг зөвлөмж тодорхой түвшинд хэрэгжсэн боловч шууд үр дүнг харьцуулах бүрэн хэрэгжсэн эсэхэд дүгнэлт хийх боломжгүй байна.

### **3.9. Аудитын илрүүлэлт**

Аудитаар 10663.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлж 450,8 мянган төгрөгийн алдааг төлүүлэхээр акт тогтоож, 10212.8 мянган төгрөгийн алдааг заруулж, 3 төрлийн зөрчилд зөвлөмж өглөө.

#### **Залруулсан алдаа**

Аудитаар шинэ байранд орсонтой холбоотой нутгийн иргэд аж ахуйн нэгжүүдийн хандиваар өгсөн хөрөнгө бараа материалыг данс бүртгэлд тусгаагүй 10212,8 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залрууллаа.

#### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн 1 алдаа илэрч төлбөрийн акт тогтоолоо. Үүнд.

1. Ажиллагсдад цалин хөлсийг илүү тооцож 450.8 мянган төгрөгийг олгосон, зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д дансны өглөг авлага, төлбөрийн тооцоог хянах ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах, заалттай нийцэхгүй, үнэн зөв бодитой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: нийт 450.8 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоов.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

## **4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. **Үндсэн хөрөнгө бараа материалын тооллого**
- 1.1. **Илрүүлэлт:** Эд хариуцагчийн тооцоо бодсон акт байхгүй байна.
- 1.2. **Эрсдэл:** хөрөнгө үрэгдэх
- 1.3. **Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6.Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх үр дүнг шийдвэрлэх бэлтгэн нийлүүлэгч худалдан авагчтай тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах гэснийг мөрдөж ажиллах
- 1.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Асуудлын бүртгэлээр нягтлан бодогчид танилцуулж гарын үсэг зуруулсан.

### **Анхан шатны баримтын бүртгэл**

- 2.1. **Илрүүлэлт:** Татварын нэгдсэн системд холбогдсон бизнес эрхлэгч, аж ахуйн нэгжээс хэвлэсэн төлбөрийн баримт дутуу
- 2.2 **Эрсдэл:** тайлан буруу илэрхийлэгдэх, хуурамч зарлага гаргах
- 2.3 **Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4.хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх зарчмыг баримтлан ажиллах
- 2.4 **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Асуудлын бүртгэлээр нягтлан бодогчид танилцуулж гарын үсэг зуруулсан.

### **Өөрийн орлого бүрдүүлэлт**

- 3.1. **Илрүүлэлт :** Тайлант жилд өөрийн орлогоор 1,0 сая төгрөг бүрдүүлэхээс 900,0 мянган төгрөгийг хандивын орлогоос, 100,0 мянган төгрөгийг байрны түрээсийн орлогоор бүрдүүлсэн нь өөрийн орлого бүрдүүлэлтийн шаардлага хангахгүй байна.
- 3.2. **Эрсдэл:** Санхүүгийн тайлан дахь орлого буруу тооцогдох төлөвлөлтөд сөрөг нөлөө үзүүлэх
- 3.3. **Өгсөн зөвлөмж :** Төлбөртэй үйлчилгээний орлого болон үйл ажиллагааны бодит үр дүнгээр олсон орлогоос өөрийн орлогыг бүрдүүлэх, орлогын нөөцийг судлан зөв бүртгэж зөв тайлагнах
- 3.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Цаашид анхаарч ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 5 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

/ Мянган төгрөгөөр/

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн/ мян.төг/	Аудитын байгуул- лагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Ажиллагсдын цалин илүү тооцож олгосон	450,8	акт	соёлын төвийн эрхлэгч	Б.Магсаржав
	актын дүн	450,8			
2	хандиваар өгсөн 14 үсэг бүхий гэрлэн хаягийн үнэ дутуу бүртгэсэн	1,468,1	залруулга	соёлын төвийн эрхлэгч	Б.Магсаржав
3	Шинэ байранд орсонтой холбоотой нутгийн иргэд аж ахуйн нэгжүүд хандив тусламж дутуу бүртгэсэн	4,372,4	залруулга	соёлын төвийн эрхлэгч	Б.Магсаржав
4	Шинэ байранд орсонтой холбоотой нутгийн иргэд аж ахуйн нэгжүүд хандив тусламжаар санхүүжүүлсэн хөрөнгө зардал бүртгээгүй	4,372,4	залруулга	соёлын төвийн эрхлэгч	Б.Магсаржав
	залруулга дүн	<b>10,212,8</b>			
5	Эд хариуцагчийн тооцоо бодож актаар баталгаажуулаагүй	0	Зөвлөмж	соёлын төвийн эрхлэгч	Б.Магсаржав
6	И баримт дутуу	0	Зөвлөмж	соёлын төвийн эрхлэгч	Б.Магсаржав
7	Өөрийн орлого 1.0 сая төгрөг гэж тайланд тусгасны 900.0 мянган төгрөг нь хандивын мөнгө 100.0 заал түрээсийн орлого байна.	0.0	Зөвлөмж	соёлын төвийн эрхлэгч	Б.Магсаржав
	НИЙТ	10,663,7			

### ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР